



ОРХОН АЙМАГ  
ЖАРГАЛАНТ СУМЫН ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН  
ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны 12 сарын 18 өдөр

Дугаар 09/25

Жаргалант сум

Ахмад настны хөгжлийн хөтөлбөрийг  
хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөө батлах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.1.18 дахь заалт, 48 дугаар зүйлийн 48.1 дэх хэсэг, 49 дүгээр зүйлийн 49.1 дэх хэсэг, Ахмад настны тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.5 дахь хэсэг, 15 дугаар зүйлийн 15.1 дэх хэсгийг тус тус үндэслэн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдаанаас ТОГТООХ нь:

1. Ахмад настны хөгжлийн хөтөлбөрийг хэрэгжүүлэх 2026 оны төлөвлөгөөг хавсралтаар баталсугай.


2. Хөтөлбөрийн хэрэгжилтийг ханган, төлөвлөгөөний биелэлтийг 2026 оны 4 дүгээр улиралд багтаан тайлагнахыг Засаг дарга (Л.Учрал), сумын Ахмадын хорооны дарга (О.Цэрэндулам) нарт тус тус даалгасугай.

ДАРГА



Ш.БИЛГҮҮНБААТАР

Сумын Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны  
12 дугаар сарын 18-ны өдрийн ээлжит IV хуралдааны  
09/25 тогтоолын хавсралт



**АХМАД НАСТНЫ ХӨГЖЛИЙН ХӨТӨЛБӨРИЙН 2026 ОНД ХЭРЭГЖҮҮЛЭХ  
АРГА ХЭМЖЭЭНИЙ ТӨЛӨВЛӨГӨӨ**

2025.12.16

Жаргалант сум

№	Хөтөлбөрийн зорилт	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Хэмжих нэгж	Үр дүнгийн үзүүлэлт			Санхүүжилт		Хариуцан хэрэгжүүлэгч
					Суурь он	Суурь түвшин	Зорилтот түвшин (2026 он)	Санхүүжилт сая.төг	Санхүүжилтийн эх үүсвэрийн нийлэг	
1	<b>Зорилт 1.</b> Ахмад настны эрүүл мэнд, эрүүл насжилтыг дэмжих	1.1. Эрүүл зөв хооллолтын зөвлөгөө, сургалтад хамруулах.	Сургалтад хамрагдсан ахмадын тоо.	Тоон үзүүлэлт	2025	100	110 ахмадын эрүүл насжилтыг дэмжсэн байна	1.0 сая	ОНХС	ЗДТГ, Ахмадын хороо, ЭМТ
2		1.2. Хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие ахмадын судалгааг гаргах.	Судалгаа гаргаж тусламжинд хамруулсан байдал.	Тоон үзүүлэлт	2025	-	Хэвтрийн өвчтэй, хөгжлийн бэрхшээлтэй ганц бие ахмадад тусламж үзүүлсэн байна.	-	ОНТ	ЗДТГ, Ахмадын хороо, ЭМТ

3		1.3. Нас барсан ахмадын гэр бүлд нэг удаа буцалтгүй тусламж үзүүлэх.	Буцалтгүй тусламжийн тоо	Тоон үзүүлэлт	2025	-	Ар гэрт гачигдал гарсан ахмад настанд буцалтгүй тусламж үзүүлсэн байна.	-	ОНТ	Ахмадын хороо
4		1.4. Хөнгөлөлттэй үнээр ахмад настанд амралт сувиллын үйлчилгээ үзүүлэх байгууллагын жагсаалтаас сонгон ахмадуудаа амарч сувилуулахад дэмжлэг үзүүлэх.	Амралт, сувилалд ахмад настангуудыг хамруулсан байдал тоо.	Тоон үзүүлэлт	2025	0	Сумын халамжийн асуудал хариуцсан мэргэжилтэнд хүсэлтийг нь уламжлан жилд 50-60 ахмад настанг сувилалд хамруулсан байна	-	ҮА	Ахмадын хороо ХХҮГ
5	<b>Зорилт 2.</b> Хөдөлмөр эрхлэлт, орлогыг нэмэгдүүлж, ядуурлаас хамгаалах	2.1. Ахмад настныг НТС төвийн болон бусад сургалтад хамруулж орлогын шинэ эх үүсвэртэй болгох.	1. Сургалтад хамрагдсан ахмад настны тоо 2. Орлогын эх үүсвэр. ( мян. төг )	Хүний тоо	2025	30	Ахмад настны амьжиргааг дэмжиж 35 ахмад настанг хамруулсан байна.	0,8 сая	ОНТ	Ахмадын хороо, НТБ төв

6		2.2. Аймгийн ХХҮГ-т хүсэлт гарган ахмадуудаа, ахмад мэргэжилтний зөвлөх үйлчилгээнд хамрагдахад нь зөвлөн тусалж хамтран ажиллах.	Зөвлөх үйлчилгээнд хамрагдсан ахмад настны тоо.	Тоон үзүүлэлт	2025	10	Мэргэжлийн түвшинд бэлтгэгдсэн иргэд олон нийтэд мэдээлэл зөвлөгөө өгөх чадварт 6 ахмад настанг хамруулна	-	ҮА	Ахмадын хороо ХХҮГ
7	<b>Зорилт 3.</b> Амьдрах орчин нөхцөлийг сайжруулахад туслах	3.1. Байгууллагуудын "Ахмадын сан"-гаас ахмад настны орон байрны нөхцөлөө сайжруулахад дэмжлэг үзүүлэх талаар санаачилгатай ажиллах.	Арга хэмжээний тоон үзүүлэлт.	Хүний тоо	2025	0	"Ахмадын сан"-гийн зарцуулах журмыг хэрэгжүүлэх, ахмадын амьжиргааг дэмжих зорилгоор 3 ахмад настанд дэмжлэг үзүүлсэн байна.	-	ҮА	Ахмадын хороо, бусад төрийн болон төсвийн байгууллага
8	<b>Зорилт 4.</b> Ахмад настны чадамжийг дэмжих, сургах, алдаршуулах	4.1. Анхдагч, алдар гавьяатай ахмадуудыг алдаршуулах, тэднээр хүүхэд залууст өв уламжлал, ёс, заншлын зөвлөгөө өгүүлэх.	Хамтран ажилласан ахмад настны тоо.	Хамрагдсан хүний тоо.	2025	1	Алдар гавьяатай ахмадын алдар гавьяаг дуурсгах, ахмад залуу үеийн холбоог бэхжүүлэх чиглэлээр 5 ахмад настантай хамтран ажиллана.	1.5 сая	ОНТ	Ахмадын хороо, ЗДТГ, ЕБС



9	4.2. Настныг софт волейбол, граунд гольф, нумт харваа зэрэг спортын тоног хэрэгсэлтэй болгож, сургаж бэлтгэх.	Спортын тоног хэрэгсэлийн бүрдэл	Тоног хэрэгсэл	2025	-	Аймаг, бүсийн тэмцээн уралдаанд оролцох боломж бүрдсэн байна.	3.2 сая	ОНХС	Ахмадын хороо, ЗДТГ
10	4.3. Сумын ахмадуудын дунд хавар намар спортын тэмцээн зохион байгуулах.	Спортын тэмцээнд хамрагдсан ахмад настны тоо.	Тоон үзүүлэлт	2025	64	Ахмадуудын чөлөөт цагийг зөв өнгөрүүлэх, эрүүл мэндийг дэмжихэд тусалж 80 ахмад настаныг хамруулсан байна.	4.0	ОНТ	Ахмадын хороо, ЗДТГ
11	4.4. Ахмадын ордонд шаардлагатай тоног төхөөрөмж техник хэрэгсэл авах (пульт, чанга яригч, утастай микрофон)	Шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангагдсан байдал	Ширхэг	2025	0	Урлагийн арга хэмжээ явуулах, цаашид нэмэлт орлого олох боломж бүрдсэн байна.	10.0 сая	ОНХС	Ахмадын хороо, ЗДТГ, СМТ
12	4.5. Ахмадын ордонд сургалтын ухаалаг дэлгэцтэй болох	Сургалтын дэлгэц 1 ширхэг	Ширхэг	2024	0	Ахмадын сургалтын танхимыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр ханган, сургалт явуулах нөхцөл бүрдсэн байна.	6.0 сая	ОНХС	Ахмадын хороо, ЗДТГ

13	Сургуулийн сурагчдад нөлөөллийн сургалт зөвлөгөө өгөх	Бага, дунд ангийн 50-аас доошгүй хүүхдэд	Хүний тоо	-	-	Уламжлалт өв соёлоо дээдлэх, дэлгэрүүлэх, ахмад настан болон бусдыг хүндэтгэх, эх орноо хайрлан хамгаалах талаар зөвлөгөө сургалт өгөх	ОН-ийн төсөв	ГХУСАЗ зөвлөл, Ахмадын хороо	Салбар ЕБС,
<b>Нийт төсөв</b>	<b>Орон нутгийн хөгжлийн сангийн санхүүжилт 21,0 (сая төг) Орон нутгийн төсвийн санхүүжилт 8,0 (сая төгрөг)</b>						29,0 (сая төгрөг)		